



СЕКЮРИТИЗ  
ҮЦК

**ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ**

**2022.02.14-2022.02.18**

---



# ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.02.21-ний байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
DOW	34,105.00	0.08%	-1.33%	-0.75%	8.20%
US500	4,349.67	0.02%	-1.19%	-1.38%	12.20%
NASDAQ	13,969.00	-0.26%	-2.08%	-3.70%	5.66%
<b>Европ</b>					
GB100	7,514.00	-0.32%	-1.92%	-1.00%	13.43%
DE40	15,043.00	-1.47%	-2.48%	-4.85%	7.50%
FR40	6,930.00	-0.25%	-1.17%	-3.39%	20.02%
IT40	26,507.00	-0.61%	-1.70%	-3.16%	14.57%
ES35	8,590.00	-0.94%	-2.37%	-2.11%	5.38%
<b>Ази</b>					
JP225	26,939.00	-0.67%	0.16%	-1.26%	-9.65%
SHANGHAI	3,476.00	-0.41%	0.80%	-1.89%	-5.56%
CSI 300	4,614.00	-0.80%	1.08%	-2.70%	-19.51%
SHANGHAI 50	3,130.00	-1.04%	0.63%	-0.76%	-21.21%
CH50	15,192.66	0.63%	0.57%	-0.25%	-24.03%
SENSEX	57,822.00	-0.02%	-0.55%	-3.77%	13.64%
<b>Эрчим хүч</b>					
WTI Газрын тос	90.93	-0.61%	-1.73%	6.63%	54.39%
Брэнт Газрын тос	93.07	-0.58%	-0.88%	6.87%	48.80%
Байгалийн хий	4.66	5.07%	12.66%	10.15%	44.67%
Шатахуун	2.66	-0.81%	-2.19%	8.82%	48.25%
Нүүрс	232.50	-0.85%	-5.10%	4.21%	170.35%
<b>Түүхий эд</b>					
Алт	1,889.65	-0.40%	2.00%	3.11%	6.45%
Мөнгө	23.73	-0.71%	1.39%	-0.95%	-12.19%
Зэс	4.53	0.09%	0.36%	1.16%	11.00%
<b>Бонд /10 жил/</b>					
Өгөөж					
АНУ	1.93	0.0416	0.01%	0.07%	0.58%
Англи	1.36	0.0990	-0.19%	0.10%	0.66%
Швейцар	0.28	0.0070	-0.06%	0.26%	0.58%
Испани	1.21	0.0180	-0.03%	0.52%	0.91%
Португаль	1.17	0.0370	0.19%	0.60%	1.06%

# ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



Эх үүсвэр: Business Insider

- Өнгөрсөн 7 хоногт АНУ-ын их зах зээлийн үнэлгээтэй компаниудын индекс буурч, дунд болон бага зах зээлийн үнэлгээтэй зах зээлийн индексүүд илүү тогтвортой байлаа.
- "Украин болон Оросын хурцадмал байдал үргэлжлэх хандлагатай байгаа тул Японы Nikkei 225 индекс 2 хувиар уналаа"
- Даваа гарагийн өглөөний арилжаагаар Ази, Номхон далайн орнуудын хувьцааны ханш уналттай нээгдэж, хөрөнгө оруулагчид Украиныг тойрсон нөхцөл байдлыг ажигласаар байна.

# ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## АНУ

Украин болон ОХУ-ын хурцадмал байдал, инфляцын өсөлт зэрэг нь хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлж томоохон индексүүд хоёр долоо хоног дараалан уналтад орлоо.

ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин АНУ болон түүний холбоотнуудтай үүссэн хурцадмал байдлыг дипломат аргаар шийдвэрлэнэ гэж найдаж байгаагаар илэрхийлж, Украины хилийн ойролцоо цэргээ хэсэгчлэн татна гэж мэдэгдсэний дараа мягмар гарагт индексүүд өссөн байна.

Цэргээ татна гэсэн мэдээ гарснаас удалгүй АНУ-ын албаны хүмүүс ухрах нотлох баримт байхгүй, халдлага удахгүй болно гэж мэдэгдсэний дараа хувьцаанууд пүрэв гарагт дахин буурчээ.

## ОХУ болон Украин улсын хөрөнгийн зах зээлд үзүүлэх үр дагавар юу вэ?

Зураг . Газрын тосны үнэ



Орос улс нь дэлхийн хамгийн том газрын тос үйлдвэрлэгч улсуудын нэг бөгөөд бүс нутгийн байгалийн хийн 40 орчим хувийг хангадаг. Орос Украин хоёр улсын таагүй харилцаа нефтийн үнийг өсгөсөөр байгаа бөгөөд WTI нефтийн үнэ 90 ам.долларт хүрснээр АНУ дэлхийн өөр томоохон газрын тос олборлогч Иран болон бусад томоохон газрын тос олборлогчдын эсрэг хориг арга хэмжээгээ цуцлах талаар хэлэлцэж байгаа нь өсөлтийг бага ч гэсэн удаашруулах хандлагатай байна.

Орос-Украины хурцадмал байдал нь зах зээлийн тогтворгүй байдал үүсгэснээр хөрөнгө оруулагчид хөрөнгөө уналтаас хамгаалах үүднээс улажлалт хөрөнгө оруулалт буюу АНУ-ын Төрийн сангийн бонд, ам.доллар, алт гэх мэт хөрөнгөрүү байршуулж магадгүй юм. Тодорхойгүй байдал улам бүр нэмэгдсээр байгаа тул сүүлийн өдрүүдэд хөрөнгө оруулагчид тогтмол өгөөжтэй, эрсдэл багатай хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнүүдэд мөнгөө байршуулж байна. Хэрэв дээрх хурцадмал байдал намжвал хөрөнгө оруулагчид ХНС-ын бодлого, инфляц болон эдийн засгийн үзүүлэлтүүдэд дахин анхаарлаа хандуулах төлөвтэй байна.


# ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## Европ

Украины асуудлаарх геополитикийн хурцадмал байдал болон мөнгөний бодлого тодорхойгүй байгаа энэ үед Европын хувьцааны ханш уналт үзүүлээ. Орон нутгийн мөнгөн тэмдэгтээр харвал Европын STOXX Europe 600 индекс 1.86%-иар буурч долоо хоногийг дуусгалаа. Германы DAX индекс 2.48%-иар, Италийн FTSE MIB индекс 1.70%-иар, Францын CAC 40 индекс 1.17%-иар тус тус унав. Их Британийн FTSE 100 индекс 1.92%-иар унасан байна.


1-р сард Их Британийн инфляц сүүлийн 30 жилийн дээд төвшинд хүрснээр Английн Төв банкнаас 3-р сард хүүгээ гурав дараалан өсгөнө гэсэн хүлээлтийг нэмэгдүүлэхэд нөлөөлөв. Хэрэглээний үнэ 1-р сард өмнөх оныхоос 5.5%-иар өссөн нь 1992 оны 3-р сараас хойших хамгийн өндөр төвшин бөгөөд 12-р сард 5.4%-иар өссөн байна.

Зураг 3. Франц CAC40, Герман DAX индекс



Эх сурвалж: Yahoo finance

Зураг 4. Евро бондын өгөөж



Эх сурвалж: European Central Bank

# ОЛОН УЛСЫН НҮҮРСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨСӨӨЛӨЛ

2021 онд "COP26" уулзалтаар нийт 40 улс нүүрсний үйлдвэр нэмж барихгүй байх үүрэг хүлээсэн. Гэвч хамгийн их нүүрс үйлдвэрлэдэг БНХАУ, ОХУ, Энэтхэг, Австрали, АНУ гэсэн 5 улсаас ердөө АНУ ирэх 2 жилд нүүрсний үйлдвэрлэлээ бууруулах төсөөлөл гарсан байна.

Олон улсын эрчим хүчний нийгэмлэгийн төсөөлж байгаагаар БНХАУ 2024 он гэхэд 3,982 сая тонн нүүрс үйлдвэрлэхээр байгаа нь нийт үйлдвэрлэлийн 50 хувийг дангаараа эзэлж байна.

Зураг 3. Нүүрсний үйлдвэрлэлийн төсөөлөл

Country	Coal Production (2021)	Coal Production (2024F)	Share (2024F)	Change (2021–2024F)
China	3,925 Mt	3,982 Mt	0.5	+57 Mt
India	793 Mt	955 Mt	0.12	+162 Mt
Indonesia	576 Mt	570 Mt	0.07	-6 Mt
United States	528 Mt	484 Mt	0.06	-44 Mt
Australia	470 Mt	477 Mt	0.06	+7 Mt
Russia	429 Mt	445 Mt	0.05	+16 Mt
European Union	329 Mt	247 Mt	0.03	-82 Mt
Other	839 Mt	855 Mt	0.11	+16 Mt

Эх сурвалж: Олон улсын эрчим хүчний нийгэмлэг

2020-2021 нүүрсний борлуулалт, экспорт /мянган тонноор/



2021 онд 15.9 сая тонн нүүрс экспортлосон нь өмнөх оны үеийнхээс 49 хувь буурсан байна.

Үндэсний статистикийн хорооны мэдээллээр Монгол улсын нийт экспортын 34 хувийг нүүрс, 36 хувийг зэсийн экспорт эзэлсэн байна.